

**Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын
“Орхон хөгжил” ХК-ийн
2019 оны газар тариалангийн
үйлдвэрлэл болон үйл ажиллагааны тайлан**

1. Тариалалтын талаар:

Тайлант 2019 онд тариалангийн ажилд ашиглах техник тоног төхөөрөмжийн засварыг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн. Мөн тоног төхөөрөмжөө шинэчлэн хор цацаг, үрлүүр, сийрүүлүүр, комбайн зээлээр худалдаж авсан.

Тариалалтыг 5-р сарын 04-ны өдрөөс 5-р сарын 29-ныг дуустал хугацаанд нийт 898 га-д хийж гүйцэтгэв. Тарихын өмнөх боловсруулалтыг трактор, сийрүүлэгчээр гүйцэтгэсэн бөгөөд 160 тн үрийг 8-10 см-ийн гүнд тариалав.

Тарианы соёлолт, ургалтын явцад бороо чийг муу байсан тул ургац хураалт тааруу байсан болно.

2. Ургац хураалтын талаар;

Комбайны засварын ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэн 3 комбайныг бэлэн болгож ажиллуулсан. Хураалтын явцад комбайны эвдрэл бага зэрэг гарсан боловч цаг тухайд засварласан.

Тайлант онд 850 га талбайд уринш хийсэн. Уриншийн талбайд гербицид хороор боловсруулалт хийсэн. Хор цацах ажлыг 6-р сарын 15-аас 6-р сарын 25 хүртэл 10 хоног гүйцэтгэв. Уриншийн 2-р үеийн боловсруулалтыг 8-р сарын 8-аас эхэлж сийрүүлэлтийг 10 хоногт хийж гүйцэтгэлээ.

Тарианы соёлолт, ургалтын явцад бороо чийг тааруу байсан тул ургац хураалт муу байсан болно. Мөндөр хүчтэй орсоны улмаас 300 га талбайн ургац хураан авч чадаагүй болно.

Ургац хураалт өөрийн автомашин техникийг ашиглан 40-45 хоног үргэлжлэв.

3. Үтрэмийн ажлын талаар;

Хураасан будаагаа өөрийн ачигч, цэвэрлэгч, сортлогч машиныг ашиглан стандартад нийцүүлэн “Алтан тариа” ХХК-руу ачуулсан болно.

2019 онд 1 га-гаас 12,24 цн буюу нийт 1099,15 тн ургац хураасан бөгөөд үүнээс 837,14 тн будаа борлуулж, 518,6 сая төгрөгний орлого олж, 621,8 сая төгрөгийн зардал гарсан бөгөөд 103,2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ЖАРГАЛСАЙХАН